

**Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын
2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан
“АШИГТ МАЛТМАЛЫН БАЯЛГИЙН УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ,
АШИГТ МАЛТМАЛЫН ОРДЫН НӨӨЦИЙГ АШИГЛАХ БОЛОМЖИЙН УРЬДЧИЛСАН
ҮНЭЛГЭЭ, УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛД
ТАВИГДАХ ҮНДСЭН ШААРДЛАГУУД БА
ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ ЖУРАМ”-ыг
өөрчлөн шинэчлэх үзэл баримтлал**

Өөрчлөх журамд баримталсан эрх зүйн заалт:

Ашигт малтмалын тухай хуулийн дараах заалтуудыг баримталсан байна. Үүнд:

48.6.1. Тухайн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг эрх бүхий байгууллагаар хийлгэж ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг жилийн дотор;

10.1.7. Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам батлах, бүтээгдэхүүний стандартыг боловсруулж батлуулах;

Журам дахь бүлгүүд:

1. Ерөнхий зүйл;
2. Журмын нэр томъёоны тодорхойлолт;
3. Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ;
4. Ашигт малтмалын ордын урьдчилсан техник, эдийн засгийн үнэлгээ;
5. Ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл;
6. Ашигт малтмалын ордыг ашиглах техникийн зураг төсөл;
7. ТЭЗҮ-ийг хадгалах ашиглах ба шинэчлэн боловсруулах;
8. ТЭЗҮ-ийг хүлээж авах – гэсэн 8 бүлэг.

Журмын зорилго: бүлэг 3, 4, 5-д тавигдах шаардлагууд ба тэдгээрийг хэлэлцэх, хүлээн авах бүхий л харилцааг зохицуулна гэжээ. Мөн хэлэлцэн хүлээн авахаас гадна, төсөл хэрэгжүүлэгч болон боловсруулагч аж ахуйн нэгжид тавих шаардлага, хэлэлцүүлэгч ба төрийн захиргааны байгууллага, журамд хяналт тавих төрийн захиргааны төв байгууллага хоорондын харилцааг зохицуулна гэж Ерөнхий зүйлийн 1 ба 2-р зүйлд заажээ.

Удиртгал буюу өөрчлөх гэж байгаа журмын талаар

Энэхүү журмыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд тухайн үеийн геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүднээс 2012 онд нийтээр мөрдөх журмын адил батлан гаргаж, мөрдүүлж эхэлснээс хойш даруй 8 жил үйлчлэх

явцад анхаарах олон асуудлууд уг журмын хэрэгжилттэй холбогдон гарсан нь журмыг өөрчлөх бодит шаардлагыг бий болгоод байна.

Тухайлбал, журам нь орд газрын нөөцийн үнэлгээнээс эхлэн түүнийг ашиглах техникийн төсөл хүртэл :

- Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ,
- Ашигт малтмалын ордын урьдчилсан техник, эдийн засгийн үнэлгээ,
- Ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл,
- Ашигт малтмалын ордыг ашиглах техникийн зураг төсөл

гэсэн 4 төрлийн бичиг баримтыг боловсруулахад тавигдах шаардлагуудыг дотоод бүтцээр нь гарчиглан авч үзэхээр боловсруулагдсан атал зөвхөн ТЭЗҮ гэдэг баримт бичгийг боловсруулах, хүлээж авах, хэлэлцүүлэх, хадгалах г.м. асуудлыг процессчилон тусгасан нь баримт бичгийн нэр, агуулга, зорилтын хооронд зөрчил үүсгэж байна. Иймээс ч техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийн журам гэж олон нийтэд ойлгогдох болсон.

Журамд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай (АМТ) хуулийн 48.6.1-р зүйлд заасан “тухайн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг эрх бүхий байгууллагаар хийлгэж ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг жилийн дотор” төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ гэсэн шаардлагын биелэлтийг хангах, хэрэгжүүлэх зорилгоор ТЭЗҮ-ийг хийлгэж, хэлэлцүүлэх шаардлагатайг дурдсан байдаг.

Гэтэл журмын 7.3 дахь заалтад “...төсөл хэрэгжүүлэгч байгууллага 5 жил тутамд ТЭЗҮ-ээ тодотгосон буюу шинээр боловсруулан хэлэлцүүлж байх үүргийг хүлээнэ” гэж хуульд тусгагдаагүй заалтыг уг журамд оруулсан байна.

Ингэснээр, төсөлд нь техникийн шинж чанартай ямар нэг томоохон өөрчлөлт ороогүй ч орд газар дээр ажиллаж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч бүр ТЭЗҮ-ээ 5 жил тутам хэлэлцүүлж Төрийн захиргааны байгууллагаар хүлээж авсан шийдвэр гаргуулах чирэгдэл үүсэх болсон ба ЭБМЗ ч ТЭЗҮ-үүдийг хэлэлцэх гэж урт дараалал бий болгодог нь уг журмын нэг гол гажуудал болж байна.

Ер нь ТЭЗҮ, түүний төрлийн баримт бичгүүд ямар зорилго, чиглэлтэй боловсруулагддаг, түүнийг ЗГ-ын байгууллагын зүгээс баталгаажуулах шаардлага бий эсэх талаар болон энэ тухай гадаад орнуудад ямар практик туршлага байдгийг авч үзэж шинээр гаргах журамд илүү хууль эрх зүйн үндэслэлтэй, олон улсын жишигт нийцсэн байдлаар тусгах шаардлагатай болно.

Орд газрын баялаг нь МУ-ын үндсэн хуулиар төрийн мэдэлд байх нийтийн өмч тул тухайн орд газрын ашиглалттай холбоотой мэдээллийг төрийн байгууллага авч үзэж хяналт тавих зохицуулалт зайлшгүй байх нь зүйтэй.

Гэхдээ орд газрын эзэмшил, эдийн засгийн үр ашиг, эрсдэлийн шинжилгээтэй холбоотой бүхий л асуудлыг тусгасан ТЭЗҮ гэсэн баримт бичгийг хэлэлцэн хүлээж авах эсэх тухай шийдвэр гаргах нь зөв эсэхийг нухацтай авч үзэх шаардлагатай. Мэдээж ТЭЗҮ-ийн техникийн болон эдийн засгийн, мөн экологийн үзүүлэлтүүдийн зарим шаардлагатай үндсэн үзүүлэлтүүдийг ЗГ болон төрийн захиргааны байгууллагууд авч байх, түүнд хяналт тавьж байх шаардлага байж болох асуудал юм.

Иймд журмыг өөрчлөхдөө орд газарт төсөл хэрэгжүүлэгчийн ТЭЗҮ-ийг Төрийн захиргааны төв байгууллагаас томилсон Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (ЭБМЗ) заавал хэлэлцэж хүлээж авах эсэх, хэрэв хэлэлцэх тохиолдолд Төрийн захиргааны байгууллагын өмнөөс зөвхөн арга зүйн үүднээс нь мэргэжлийн төрийн бус байгууллагууд ч хэлэлцдэг боломж нөхцөл байгаа эсэхийг тодруулж шийдэх ёстой.

Одоогийн мөрдөж буй журмаар хэрэв төсөл хэрэгжүүлэгч нь ТЭЗҮ-ээ мөрдөх явцад алдагдалд орох тохиолдолд ТЭЗҮ-ийг хэлэлцсэн ЗГ-ыг төлөөлж буй төрийн захиргааны байгууллага, түүнээс томилогдсон ЭБМЗ хариуцлага хүлээх эсэх асуудлыг ч шинээр гаргах журамд анхааран шийдвэрлэх ёстой. Магадгүй хувийн хөрөнгө оруулалтын ТЭЗҮ-ийг компани өөрөө мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулан батлах, төрийн өмчтэй компанийн ТЭЗҮ-ийг Төрийн захиргааны байгууллагаар хэлэлцүүлэн баталдаг байдлаар журамд тусгах боломжтой юм.

Иймд дээр дурдсан зангилаа асуудлуудыг энэ журмыг өөрчлөн шинэчлэхдээ анхааран шийдвэрлэх шаардлагатай байна.

Журмыг өөрчлөх асуудлаар УУХҮЯ-аас АМЕП-2 төсөлд хүсэлт тавьсан. Энэ журам нь нийтээр дагаж мөрдөх журмын адил мөрдөгдөж бүхий л нөөц нь батлагдсан орд газруудыг ашиглах төслүүд болон ашиглалт явагдаж байгаа төслүүдийн 5 жил тутамд шинэчилсэн ТЭЗҮ боловсруулж Төрийн захиргааны төв байгууллагаас томилсон Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хэлэлцүүлдэг зарчмаар хэрэгжиж байна.

Орд газрыг ашиглах ТЭЗҮ-ээс гадна ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уурхайн техникийн төсөл боловсруулах шаардлагуудыг өөрчлөх журамд тусгагдсан

байсан ч хэрэгжих хугацаанд нэг ч дээрх төрлийн бичиг баримтуудыг журмын дагуу боловсруулж хэлэлцүүлээгүй болно.

Энэ нь дээрх журамд зөвхөн ТЭЗҮ хүлээж авах, хадгалах тухай тусгайлан заасантай ч холбоотой байж болох, эсвэл хуульд орд ашиглагч ТЭЗҮ-тэй байна гэсэн заалттай ч холбоотойгоор зөвхөн ТЭЗҮ-ийг л зохицуулж байдаг байж болох юм.

1. Журмыг өөрчлөх үндсэн шаардлагууд

ТЭЗҮ-ийн журам гэж нэрлэгдэж буй тухайн үеийн ЭБЭХ-ний Сайдын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам” нь хуульд тухайн журмыг гаргах талаар ороогүй тул нийтээр дагаж мөрдөх харилцааг зохицуулж байгаа нь түүнийг өөрчлөх нэг үндсэн шаардлага юм.

Энэ журам нь хэт урт нэртэй атлаа нэршил болон журмын дотор нь тусгагдсан 4 төрлийн баримт бичгээс зөвхөн орд газрыг ашиглах ТЭЗҮ-ийг хэлэлцэн хүлээж авахаар ашиглагдаж байгаа нь энэ журмын бас нэг өрөөсгөл тал.

Мөн тодорхой хугацааны дараа буюу 5 жил тутам орд газрыг эзэмшигч өөрийн төслийн ТЭЗҮ-ийг тодотгон шинэчлэн хийж байх, ер нь ТЭЗҮ-ийг өмчийн төрлийг үл харгалзан ЗГ-ын байгууллагаас томилсон зөвлөл хүлээж авдаг нь төслийн аюулгүй ажиллагаа, санхүүгийн эрсдэл зэргийг ч давхар хүлээж авах үйл ажиллагаа явагдаж байгаа нь эрх зүйн хувьд оновчтой эсэх, хоёрт хэрэв төсөл алдагдалд орж хохирол хүлээхэд хүлээж авсан төрийн захиргааны байгууллага хариуцлага хүлээх эрсдэл байгаа зэргийг залруулах шаардлагатай болно.

Журамд орд газрыг ашиглах уул уурхайн төслийн техникийн болон эдийн засгийн агуулгатай баримт бичгүүдийг доторх гарчгийн агуулгаар нь боловсруулахаар тусгагдсан ч өнөөгийн МУ-ын уул уурхайн салбарт мөрдөгдөх уул уурхайн төслийн техникийн болон эдийн засгийн норм, заавар, стандарт байхгүй байгаа тул дээрх гарчигласан баримт бичгүүдийн агуулгыг яаж тодорхойлох арга зүйн бааз байхгүй байгаа нь журмыг зөв хэрэгжүүлэх техникийн боломжгүй болгож байна.

Иймд ТЭЗҮ, түүнтэй ижил баримт бичгийг боловсруулах арга зүй, зааврыг мэргэжлийн холбоодтой хамтран боловсруулж мөрдүүлсний үндсэн дээр журмаар зохицуулахаар тусгах шаардлага тавигдаж байна.

Зохицуулж байгаа харилцааны мөн чанар ойлгомжгүй учир мөрдөж буй талуудад хүндрэл гардаг, нэгдсэн аргачлалгүй, зөвлөлийн эрх зүй нь тодорхой бус, ямар учраас зохицуулаад байгаа нь ойлгомжгүй г.м. байдал уг журмын мөрдөх явцад үүсээд байгаа нь журмыг өөрчлөх бас нэг шалтгаан болж байна.

2. Одоогийн журмын дутагдалтай талууд

ЭБЭХ-ний сайдын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан журмын дээр дурдсанаас гадна өөр дутагдалтай талууд нь ашигт малтмалын орд газрыг эзэмшихтэй холбогдсон голлох баримт бичгүүдийг боловсруулах, хэлэлцүүлэх, түүнд дүгнэлт гаргах шинжээчийн шаардлага болон гарсан баримт бичгийг хүлээж авах, хадгалах хүртэл олон харилцааг базсан, 4 төрлийн баримт бичгийн шаардлага гэж гарчгийн жагсаалт гаргасан ч зөвхөн 1-ийг нь баримтлан хүлээж авч байгаа зэрэг болно.

Мөн бичиг баримтуудын агуулгыг харуулсан хэсгийг харьцуулан судалж үзэхэд ямар нэг нарийвчлал, арга зүйн ялгааг харуулалгүй гарчгийн дарааллаар хийсэн тал ажиглагдаж байна.

Журамд боловсруулах бичиг баримтын тухайд нүүр хуудас, хэн хэнийг хаана бичих зэрэг хэт жижиг загварчилсан асуудал олон орсон нь хэт хуучинсаг зааврын шинжтэй байгаа болно.

Энэ журамд байгаа орд газрыг ашиглах төслийн ТЭЗҮ гээд байгаа баримт бичигт тавигдаж байгаа гарчигласан шаардлага нь ашиглаж буй ордуудын төрөл бүрд тохирохгүй байна. Тухайлбал ил, далд уурхайн болон геотехнологи бүхий уурхайнуудын нээлтийн схем өөр өөр байх зэрэг олон ялгаатай талууд бий.

Ер нь ТЭЗҮ гэсэн баримт бичгийг хэлэлцэх шаардлагатай эсэх, хэлэлцэж хүлээж авах зорилгыг илүү тодорхой болгох, хэлэлцэж буй зөвлөл ямар статустай болохыг ч илүү тодорхой болгох.

Цаашлаад олон улсад ийм төрлийн бичиг баримтад арга зүйн ямар шаардлага тавьдаг, түүнийг баталгаажуулах процедурыг хэрхэн явагддагтай уялдуулж журмыг авч үзэх ёстой.

Энд мөн орд газрын ямар ангиллын нөөц дээр ТЭЗҮ ба түүнтэй ижил төрлийн баримт бичгүүдийг боловсруулахыг дурдаагүй нь гарах баримт бичгийн үндэслэлийг

алдагдуулж байна. Учир нь ангилал нь тодорхойгүй геологийн нөөц дээр боловсруулсан ТЭЗҮ нь үндэслэлгүй баримт бичиг болох бүрэн магадлалтай.

3. Журамд тусгах шаардлагатай асуудлууд

74 дүгээр тушаалаар батлагдсан журмыг шинэчлэн өөрчлөхдөө өнөөгийн уул уурхайн практикт гол хэрэглэгдэх орд газрын нөөцийг баталгаажуулах, ашиглахтай холбогдсон 2 бичиг баримтыг тусгах нь зүйтэй. Нэгдүгээрт, орд газруудын нөөцийг тогтооход ашигладаг орд газрын кондицийн үзүүлэлтүүдийг тогтоох ТЭЗҮ буюу нөөцийн кондицийн урьдчилсан ТЭЗҮ, хоёрдугаарт орд газрын ашиглалтын төслийн ТЭЗҮ юм.

Энэ 2 баримт бичгийн агуулга, арга зүйг уул уурхайн мэргэжлийн холбоо зөвлөмж хэлбэрээр боловсруулан гаргах ба дээрх төслүүдэд ашиглах нөөц нь эхний кондицийн ТЭЗҮ-д таамаг нөөц, нөгөөх ашиглалтын төслийн ТЭЗҮ-д эдийн засгийн үр ашигтай нөөцийг авч үзэж тооцоолол хийдэг байхаар шинэчлэх журамд тусгах шаардлагатай болно.

Ямар бичиг баримтыг журмаар зохицуулах, түүнд төрийн ба төрийн бус байгууллагын оролцоог тодорхойлох, олон улсын туршлагад нийцүүлэх, ТЭЗҮ-ийг хэлэлцэх, эс хэлэлцэхийг шийдэх, Зөвлөх ба шинжээчийн үүрэг, чиглэлийг тодорхой болгох, зохиогчийн хяналт, хариуцлагыг тодотгох, арга зүйг мэргэжлийн төрийн бус байгууллагад даалгах г.м асуудлуудыг товч тодорхой зааж оруулах шаардлагатай. Талуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгох нь шинэ гаргах журамд тусгах шаардлагатай асуудлуудын нэг юм.

Журмыг өөрчлөх талаар тусгайлсан хэлэлцүүлэг УУХҮЯ дээр 2019.11.06-нд явагдаж төрийн захиргааны байгууллага, уул уурхайн мэргэжлийн холбоод болон зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий компаниудын төлөөлөл оролцон дараах саналыг гаргасан.

Үүнд, журмыг өөрчлөхөд бүгд санал нийлсэн ба мөн ТЭЗҮ-ийг нэгдсэн арга зүйгээр боловсруулдаг байх, агуулга, хүрээг нарийвчлан тогтоох, мөн байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал зэрэг хуулиар төслийн үйл ажиллагаанд зайлшгүй мөрдөгддөг бүлгүүдийг зөвхөн зардлын үзүүлэлтээр нь тусгах; мөн ЭБМЗ-ийн үйл ажиллагаа, төсөл хэлэлцэх, хүлээж авах ажиллагааг нээлттэй, ил тод, боловсронгуй болгох; шинжээч, зөвлөхүүдийн хариуцлага, эрх үүргийг тодорхой болгож журмыг илүү ойлгомжтой (боловсронгуй) болгох, ордуудын нөхцөл, уурхайн төрлөөс

хамааруулсан арга зүйг авч үзэх; ТЭЗҮ-ийг хууль эрх зүйн хувьд ямар бичиг баримт болохыг тодорхойлох, боловсруулагч компанийн эрх зүйн чадамжийг тодорхой болгох; оролцогчдод тавих шаардлагыг нэмэгдүүлэх, ТЭЗҮ боловсруулагчид тавих шаардлагыг шинэчлэх, чанаржуулах; шинжээчийн хөлсний тариф тогтоох зэрэг саналууд гарсныг шинээр боловсруулах журамд анхаарч авч үзэх.

Мөн журмын төслийг мэргэжлийн байгууллагууд, оролцогч талуудаар хэлэлцүүлэн гарсан санал, шүүмжийг мөн анхааран, журамд тусгах эсэх талаар нарийвчлан авч үзэх шаардлагатай.

4. Журмын хууль эрх зүйн үндэслэл

ТЭЗҮ-ийн журмыг шинэчлэхдээ эрх зүйн үндэслэлтэй болгож энэ тухай заалтыг АМТ хуульд тусгах шаардлагатай. Хэрэв хууль зүйн үндэслэлийг бий болгож чадахгүй бол журмын үндсэн зохицуулалтыг ЗГ-аас батлан гаргадаг “Техникийн зохицуулалт” гэсэн баримт бичгийн хэлбэрээр, эсвэл стандарт болгон гаргаж мөрдүүлэх нь зүйтэй болно.

Мөн өнөөгийн практикт тухайн орд газрыг ашиглах асуудлыг ТЭЗҮ-ийн тооцоогоор тооцоолоход эдийн засгийн хувьд ашиггүй байх тохиолдол гардаг. Энэ тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч болон ТЭЗҮ-ийг хэлэлцэж буй зөвлөл заавал ашигтай болгох нөхцөл тавьж, үндэслэлгүй, тооцооны алдаатай баримт бичиг гаргадаг практикийг эрх зүйн хувьд өөрчлөхөөр журамд тусгах.

Ер нь шинэчлэх журмын эрх зүйн үндэслэлийг нь тодорхой болгох, магадгүй заавал хуульчлахгүй, сайн туршлага, зөвлөмжөөр мөрдөж болох үндэслэлийг бий болгож гаргах шаардлагатай юм.

5. Гадаадын туршлага ба түүнээс тусгах асуудлууд

Журам шинэчлэхтэй уялдан барууны орнууд, тэр дундаа Австрали, Канадын зарим туршлагыг тусгайлан судалсан үр дүнг авч үзэх шаардлагатай. Энд манай улсад хэрэглэж байгаа ТЭЗҮ-тэй ижил агуулгатай “Feasibility Study” гэсэн баримт бичгийг орд газрыг ашиглах хөрөнгө оруулалтыг босгоход л ашигладаг, учир нь эдийн засгийн агуулга нь тухайн цаг үед үнэн зөв байдаг бөгөөд төслийн цаашдын хөгжилд өөрчлөгддөг. Харин уул уурхайн төслийн урьдчилсан ТЭЗҮ буюу “Prefeasibility Study” гэсэн баримт бичгийг нөөцийн тооцоонд кондицийн үзүүлэлтийг тогтоож

үйлдвэрлэлийн нөөц бий болгодог манай баримт бичигтэй адил зориулалтаар боловсруулж ашигладаг байна.

Дээрх улсуудын туршлагаар ТЭЗҮ болон түүнтэй ижил баримт бичгийг засгийн газрын байгууллага хэлэлцдэггүй, хөрөнгө оруулах талууд авч үздэг, харин түүнийг мэргэжлийн холбоодын заавар аргачлалаар тэр байгууллагаас итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд боловсруулдаг байна. Иймд шинэ журамд дээрх туршлага, дадлагыг харгалзан МУ-ын уул уурхайн салбарын онцлогт тохируулан зарим талаар тусгах шаардлагатай болно.

Ялангуяа ТЭЗҮ-ийг аль нэг төрийн захиргааны байгууллага хэлэлцдэггүй, төрийн бус байгууллагаас итгэмжлэгдсэн мэргэшсэн мэргэжилтэн боловсруулдаг болон арга аргачлалыг мэргэжлийн байгууллагууд зөвлөмж хэлбэрээр гаргадаг зэрэг онцлог байдлыг шинэ журам боловсруулахад анхаарч авч үзэх шаардлагатай.

6. Журмаар зохицуулах харилцаа ба гарах журмын бүтэц, бүрэлдэхүүн

Зохицуулах харилцааны хувьд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орд газрынхаа нөөцийг баталгаажуулахад ашигладаг кондицийн ТЭЗҮ буюу урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулан нөөц бүртгэх байгууллагаар батламжлуулдаг байх. Энэ бичиг баримтын зорилго нь нөөцийн тайланг боловсруулахад ашиглах гол үзүүлэлтийг тодорхойлж байгаагаар онцлог болно.

Ингэснээр хуучин журамд байсан эрдэс баялгийн салбарт илүү шаардлагатай баримт бичгүүд болох нөөцийн тооцоонд ашиглах кондицийн үзүүлэлтүүдийг тодорхойлдог урьдчилсан ТЭЗҮ, мөн орд газрыг ашиглах ТЭЗҮ гэсэн 2 баримт бичгийн талаар авч үзэх, эдгээртэй уялдсан харилцааг хууль эрх зүйд нийцүүлэн тусгах.

Хуучин журам дахь бусад бичиг баримт өнөөгийн эрдсийн салбарын харилцаанд заавал журмаар зохицуулах шаардлагагүйгээр оршиж байна.

Түүнчлэн, авч үзэх бичиг баримтыг боловсруулах арга зүйг зүйлчлэн заахгүй зөвхөн мэргэжлийн төрийн бус байгууллагаас тогтоосон арга зүйд нийцүүлэн боловсруулсан байхаар заах. Дээрх бичиг баримтууд нь зарчмын өөрчлөлт орохгүй бол анх хэлэлцүүлсэн хэвээр хадгалагдаж байхаар эрх зүйг журамд тусгах нь зүйтэй болно.

Мөн Төрийн захиргааны байгууллага ТЭЗҮ-ийн хэлэлцэн баталгаажуулдаг харилцааг өөрчлөх нь зүйтэй. Илүү тодорхой аргачлалтай болгох, оролцогч талуудыг тодорхой болгох зэрэг асуудлуудыг журам өөрчлөх тухай уулзалтанд оролцогчдоос санал асуулгаас гарсан асуудлууд тул шинэ гаргах журмын зохицуулах харилцаанд авч үзэж тусгах нь зүйтэй.

ТЭЗҮ-ийн журам гэж албан бусаар нэрлэж буй ЭБЭХ-ний сайдын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан журмыг шинэчлэн өөрчлөхдөө мэдээж хуучин журмын гол бүлгүүд болох Ерөнхий зүйл /зорилго чиглэл, зохицуулах харилцааг хайрцаглан заасан/, Нэр томъёо ба тодорхойлолт, мөн журамд авч үзэх гол бичиг баримтууд болох орд газрын урьдчилсан ТЭЗҮ буюу кондицийн ТЭЗҮ ба орд газрыг ашиглах уул уурхайн төслийн ТЭЗҮ –үүдийн талаарх тодорхойлолт, ерөнхий бүтэц, арга зүйн хэсгүүдийг товч тодорхой тус бүрд нь нэг бүлэг болгох.

Мөн ТЭЗҮ ба түүнтэй төстэй бичиг баримтыг боловсруулагчдад тавих шаардлага ба эрх зүйн талаарх бүлгийг журмын бүтэц бүрэлдэхүүнд оруулах боломжтой.

Шаардлагатай тохиолдолд зарим бүлгийг нэмж боловсруулан журамд тусгах боломжтой. Журамд арга зүйн болон бусад чиглэлээр хавсралтуудыг тусган оруулж болно.

-oOo-